

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүнс хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/177/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Булган аймаг 2023 он</p>	<p>Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Цэрэнлхам Утас: 7034-2495 Цахим хаяг: Tserenlhamg@audit.gov.mn</p>
---------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17
5.1 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
БУА	Булган аймаг
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.08.24 № 170
танай _____ ны № _____ т

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
ГАЗРЫН ДАРГА Ч.АМГАЛАН
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

ХХААХҮЯ-наас суурин компьютер, гурван үйлдэлт принтер, зөөврийн компьютер нийт 16,274.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шилжүүлэн авч, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 20,998.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 27,668.2 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг ТӨБЗ-ын 2022 оны 456 дугаар тогтоолоор акталж данснаас хассан нь үндсэн хөрөнгө буурахад нөлөөлсөн байна.

Аудитын гол асуудал

Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг хэрэгжүүлээгүй, зардлыг эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн худалдан авалт хийсэн нь үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

006020202

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	99,707,424.69	94,901,556.69
34	УРЬДЧИЛГАА	7,200,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	7,200,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	92,507,424.69	94,901,556.69
351	Түүхий эд материал	90,064,424.69	92,458,556.69
35110	Тусгай зориулалттай материал	90,064,424.69	92,458,556.69
354	Хангамжийн материал	2,443,000.00	2,443,000.00
35420	Аж ахуйн материал	129,840.00	129,840.00
35470	Бусад хангамжийн материал	2,313,160.00	2,313,160.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	368,968,075.25	357,826,620.81
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	368,968,075.25	357,826,620.81
392	Биет хөрөнгө	357,678,075.09	347,336,620.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	323,142,390.65	323,142,390.65
39202	Хуримтлагдсан элэгдэл	(29,415,973.32)	(39,221,297.76)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	193,354,000.00	193,354,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(142,466,500.00)	(153,979,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	78,319,705.10	73,595,354.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	(71,520,552.14)	(54,409,833.62)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,919,031.26	24,250,818.48
39208	Хуримтлагдсан элэгдэл	(45,654,026.46)	(19,395,811.28)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,959,112.00	1,959,112.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,959,112.00)	(1,959,112.00)
393	Биет бус хөрөнгө	11,290,000.16	10,490,000.24
39301	Программ хангамж	7,008,145.00	7,008,145.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,668,144.84)	(5,468,144.76)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,950,000.00	8,950,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	468,675,499.94	452,728,177.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	6,486,500.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	6,486,500.00
413	Өглөг	-	6,486,500.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	6,486,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	468,675,499.94	446,241,677.50
51	Засгийн газрын хувь оролцоо	468,675,499.94	446,241,677.50
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	699,279,245.10	699,279,245.10
51101	Өмч:- төрийн	699,279,245.10	699,279,245.10
512	Хуримтлагдсан үр дүн	(376,870,389.79)	(395,082,591.23)
51210	Өмнөх үеийн үр дүн	(445,429,128.02)	(372,648,768.79)
51220	Тайлант үеийн үр дүн	68,558,738.23	(22,433,822.44)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	146,266,644.63	142,045,023.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	468,675,499.94	452,728,177.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	540,018,918.70	467,119,248.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	110,065,562.70	55,478,937.00
120	Нийтлэг татварын бус орлого	110,065,562.70	55,478,937.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	110,065,562.70	55,478,937.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	110,065,562.70	55,478,937.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	429,953,356.00	411,640,311.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	421,600,900.00	382,591,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	421,600,900.00	382,591,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,352,456.00	29,048,911.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,061,456.00	21,748,911.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	291,000.00	7,300,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	471,460,180.47	460,104,746.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	451,499,146.47	460,104,746.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	439,621,220.01	387,662,925.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	244,925,719.00	221,788,326.00
210101	Үндсэн цалин	196,666,286.00	161,712,935.00
210102	Нэмэгдэл	40,273,514.00	38,200,231.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,985,919.00	7,993,940.00
210104	Урамшуулал	-	13,881,220.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,464,625.54	28,316,953.53
210201	Тэтгэврийн даатгал	22,520,099.93	20,082,103.52
210202	Тэтгэмжийн даатгал	2,435,307.67	2,105,007.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,948,246.09	1,677,286.27
210204	Ажилгүйдлийн даатгал	414,633.99	404,777.82
210205	Эрүүл мэндийн даатгал	4,146,337.86	4,047,778.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,582,122.00	33,784,862.00
210301	Гэрэл, цахилгаан	1,833,058.00	2,928,786.00
210302	Түлш, халаалт	18,475,044.00	28,540,836.00
210303	Цэвэр, бохир ус	1,274,020.00	2,315,240.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,336,121.22	19,275,340.00
210401	Бичиг хэрэг	1,644,378.70	1,814,400.00
210402	Тээвэр, шатахуун	17,166,814.00	14,693,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,356,980.00	1,639,440.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	129,000.00	728,500.00
210408	Бараа материал акталсны зардал	2,938,948.52	-
2105	Норматив зардал	347,300.00	280,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	347,300.00	280,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,556,300.00	1,337,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	75,000.00	49,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	144,000.00	109,500.00
210604	Урсгал засвар	3,337,300.00	1,179,000.00

2107	Томилолт, зочны зардал	10,207,000.00	11,385,800.00
210702	Дотоод албан томилолт	10,207,000.00	11,385,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	72,719,084.00	40,802,710.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	67,288,442.00	31,785,061.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	151,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,277,100.00	1,073,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,075.00	448,675.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,600,000.00	7,200,000.00
210807	Газрын төлбөр	91,467.00	67,474.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,482,948.25	30,691,334.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,854,535.00	3,275,480.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,628,413.25	27,415,854.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,877,926.46	72,441,820.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,990,000.00	23,133,490.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	16,640,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,990,000.00	6,493,290.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,887,926.46	49,308,330.47
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,887,926.46	49,308,330.47
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,961,034.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	19,961,034.00	-
221001	Их засвар	19,961,034.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	68,558,738.23	7,014,501.56
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	29,448,324.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	29,448,324.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(29,448,324.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	68,558,738.23	(22,433,822.44)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	699,279,245.10	146,266,644.63	(445,429,128.02)	400,116,761.71
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	699,279,245.10	146,266,644.63	(445,429,128.02)	400,116,761.71
3	Тайлант үеийн үр дүн	-	-	68,558,738.23	68,558,738.23
4	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	699,279,245.10	146,266,644.63	(376,870,389.79)	468,675,499.94
5	2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	699,279,245.10	146,266,644.63	(376,870,389.79)	468,675,499.94

6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	4,221,621.00	4,221,621.00
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	699,279,245.10	146,266,644.63	(372,648,768.79)	472,897,120.94
8	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(4,221,621.00)	-	(4,221,621.00)
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(22,433,822.44)	(22,433,822.44)
10	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	699,279,245.10	142,045,023.63	(395,082,591.23)	446,241,677.50

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	431,949,092.00	419,002,392.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	431,949,092.00	419,002,392.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	421,600,900.00	382,591,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	421,600,900.00	382,591,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,348,192.00	36,410,992.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,061,456.00	21,748,911.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,286,736.00	7,300,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	7,362,081.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	431,949,092.00	419,002,392.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	431,949,092.00	419,002,392.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	420,071,165.54	346,560,571.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	244,925,719.00	221,788,326.00
210101	Үндсэн цалин	196,666,286.00	161,771,145.00
210102	Нэмэгдэл	40,273,514.00	38,151,808.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,985,919.00	7,984,153.00
210104	Урамшуулал	-	13,881,220.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,464,625.54	28,316,953.53
210201	Тэтгэврийн даатгал	22,520,099.93	20,082,103.52
210202	Тэтгэмжийн даатгал	2,435,307.67	2,105,007.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,948,246.09	1,677,286.27
210204	Ажилгүйдлийн даатгал	414,633.99	404,777.82
210205	Эрүүл мэндийн даатгал	4,146,337.86	4,047,778.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,582,122.00	33,784,862.00
210301	Гэрэл, цахилгаан	1,833,058.00	2,928,786.00

210302	Түлш, халаалт	18,475,044.00	28,540,836.00
210303	Цэвэр, бохир ус	1,274,020.00	2,315,240.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,556,380.00	16,151,340.00
210401	Бичиг хэрэг	1,570,900.00	1,814,400.00
210402	Тээвэр, шатахуун	10,379,500.00	11,693,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,356,980.00	1,639,440.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	129,000.00	604,500.00
2105	Норматив зардал	347,300.00	280,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	347,300.00	280,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,914,000.00	1,337,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	75,000.00	49,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	144,000.00	109,500.00
210604	Урсгал засвар	3,695,000.00	1,179,000.00
2107	Томилолт, зочны зардал	10,850,000.00	4,899,300.00
210702	Дотоод албан томилолт	10,850,000.00	4,899,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	89,179,134.00	36,602,710.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	76,548,492.00	34,785,061.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	151,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,277,100.00	1,073,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,075.00	448,675.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,800,000.00	-
210807	Газрын төлбөр	91,467.00	67,474.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,251,885.00	3,399,480.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,251,885.00	3,399,480.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,877,926.46	72,441,820.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,990,000.00	23,133,490.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	16,640,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,990,000.00	6,493,290.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,887,926.46	49,308,330.47
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,887,926.46	49,308,330.47
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	382,591,400.00	340,645,150.53	41,946,249.47	89.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	382,591,400.00	340,645,150.53	41,946,249.47	89.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	359,351,400.00	317,511,660.53	41,839,739.47	88.4

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	258,121,500.00	221,788,326.00	36,333,174.00	85.9
210101	Үндсэн цалин	199,501,700.00	161,771,145.00	37,730,555.00	81.1
210102	Нэмэгдэл	44,051,600.00	38,151,808.00	5,899,792.00	86.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,986,000.00	7,984,153.00	1,847.00	100.0
210104	Урамшуулал	6,582,200.00	13,881,220.00	(7,299,020.00)	210.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,265,100.00	28,316,953.53	3,948,146.47	87.8
210201	Тэтгэврийн даатгал	21,940,300.00	20,082,103.52	1,858,196.48	91.5
210202	Тэтгэмжийн даатгал	2,581,200.00	2,105,007.84	476,192.16	81.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,065,000.00	1,677,286.27	387,713.73	81.2
210204	Ажилгүйдлийн даатгал	516,200.00	404,777.82	111,422.18	78.4
210205	Эрүүл мэндийн даатгал	5,162,400.00	4,047,778.08	1,114,621.92	78.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,967,600.00	33,784,862.00	1,182,738.00	96.6
210301	Гэрэл, цахилгаан	3,816,300.00	2,928,786.00	887,514.00	76.7
210302	Түлш, халаалт	28,634,800.00	28,540,836.00	93,964.00	99.7
210303	Цэвэр, бохир ус	2,516,500.00	2,315,240.00	201,260.00	92.0
2104	Хангамж, бараа материалын зардал	16,303,300.00	16,151,340.00	151,960.00	99.1
210401	Бичиг хэрэг	1,819,600.00	1,814,400.00	5,200.00	99.7
210402	Тээвэр, шатахуун	11,693,000.00	11,693,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,728,700.00	1,639,440.00	89,260.00	94.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	453,100.00	400,000.00	53,100.00	88.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	608,900.00	604,500.00	4,400.00	99.3
2105	Норматив зардал	283,500.00	280,100.00	3,400.00	98.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	283,500.00	280,100.00	3,400.00	98.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,364,700.00	1,337,500.00	27,200.00	98.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	63,300.00	49,000.00	14,300.00	77.4
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	118,200.00	109,500.00	8,700.00	92.6
210604	Урсгал засвар	1,183,200.00	1,179,000.00	4,200.00	99.6
2107	Томилолт, зочны зардал	4,899,300.00	4,899,300.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	4,899,300.00	4,899,300.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,743,300.00	7,553,799.00	189,501.00	97.6

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,749,600.00	5,736,150.00	13,450.00	99.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	151,300.00	151,300.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,073,200.00	1,073,200.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	518,700.00	448,675.00	70,025.00	86.5
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	151,300.00	77,000.00	74,300.00	50.9
210807	Газрын төлбөр	99,200.00	67,474.00	31,726.00	68.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,403,100.00	3,399,480.00	3,620.00	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,403,100.00	3,399,480.00	3,620.00	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,240,000.00	23,133,490.00	106,510.00	99.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,240,000.00	23,133,490.00	106,510.00	99.5
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	16,640,200.00	16,640,200.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,599,800.00	6,493,290.00	106,510.00	98.4
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
6	төсвийн бусад мэдээллийн ангилал	22	20	2	90.9
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21	19	2	90.5
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	19	17	2	89.5
620003	Үйлчлэх ажилтан	1	1	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	29,048,911.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	29,048,911.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	29,048,911.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,048,911.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,048,911.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	29,048,911.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	29,048,911.00

131103	ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,748,911.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,300,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь мал үржлийн алба, үйлдвэрлэл худалдаа үйлчилгээний алба, захиргаа аж ахуйн гэсэн 3 албатайгаар төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлэх бодлого, шийдвэр, хөтөлбөрүүдийг аймагтаа хэрэгжүүлэн ажилласан байна.

2022 онд “Орон нутгийн эдийн засгийн өсөлтийг хангаж, бүс нутгийн болон хөдөөгийн хөгжлийг дэмжих, хүнс, хөдөө аж ахуйн салбарын тогтвортой байдлыг хангах, шинжлэх ухаан технологийн ололтыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх” зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ✓ Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд хөдөө аж ахуйг эрчимтэй хөгжүүлэх
- ✓ Мал аж ахуйн үйлдвэрлэлийн ололтыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх
- ✓ Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг дээшлүүлэх
- ✓ Байгалын аливаа эрсдэлээс хамгаалах
- ✓ Хөдөөд хүмүүс ая тухтай амьдрах нөхцөлийг улам сайжруулах
- ✓ Малын үйлдвэр угсааг сайжруулж хууль, эрх зүйн хүрээнд зохион байгуулах
- ✓ Малчдын хөдөлмөрөөрөө хорших хоршоог бүх талаар нь хөгжүүлэх
- ✓ Хөнгөн, хүнсний үйлдвэрийг хөгжүүлэх

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/63 тоот тушаалаар захиргаа аж ахуйн алба 12, мал үржлийн алба 5, үйлдвэр худалдаа, үйлчилгээний алба 4 нийт 21 орон тоотой байхаар баталжээ. Гүйцэтгэлээр 2022 онд удирдах 1, гүйцэтгэх 17, үйлчлэх 1 нийт 19 орон тоотойгоор үйл ажиллагаагаа хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг үзүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь Хүнсний аюулгүй байдлын тухай хууль, Хоршооны тухай хууль, Таримал ургамлын үр сортын тухай хууль, Мал амьтны үрүүл мэндийн тухай хууль, Малын генетик нөөцийн тухай хууль, Тариалангийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль болон түүнийг дагалдаж гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдан 2022 оны 5 сараас зарим заалтууд нь хэрэгжиж эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус газрын хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтний орон тоо байхгүй, захиргаа удирдлагын хэлтсийн дарга хавсран гүйцэтгэдэг боловч 2022 онд хөдөө

аж ахуй, газар тариалан, захиргаа, санхүүгийн чиглэлээр ямар нэгэн хяналт хэрэгжүүлсэн тайлан мэдээ байхгүй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын даргын баталсан бодлогын баримт бичиг баримт байхгүй, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны сайдын 2019 оны А/385 тушаал баталсан НБББББ-ыг үйл ажиллагаандаа ашиглаж байна. 2022 онд бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15,947.3 мянган төгрөгөөр буюу 3.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	7,200.00	-	(7,200.00)
Бараа материал	92,507.42	94,901.56	2,394.13
Үндсэн хөрөнгө	368,968.08	357,826.62	(11,141.45)
Нийт хөрөнгө	468,675.50	452,728.18	(15,947.32)
Өр төлбөр	-	6,486.50	6,486.50
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	468,675.50	446,241.68	(22,433.82)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	468,675.50	452,728.18	(15,947.32)

Дээрх хүснэгтээс харахад 2022 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан данс нь урьдчилгаа, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн оролцоо данснууд байна.

Үндсэн хөрөнгө буурсан шалтгаан нь машин тоног төхөөрөмж 20,998.7 мянга, тавилга эд хогшил 27,668.2 мянган төгрөгийг ТӨБЗ-ын 2022 оны 456 дугаар тогтоолоор акталж данснаас хассантай холбоотой байна. Бараа материал данс өсөхөд ХХААХҮЯ-наас мал жинлэгч, таяган метр, туузан метр нийт 2,394.1 мянган төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд тусгасантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 496,595.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Хүргүүлсэн төсвийн төслийн саналаас зардлыг 114,004.3 мянган төгрөгөөр бууруулж, 382,591.4 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь өмнөх оны төсвийн гүйцэтгэлд үндэслэсэн мөн оготно усгалын арга хэмжээ, хоршоог хөгжүүлэх арга хэмжээний зардал хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцын батлагдсан төсөвт тусгагдаагүйгээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийг тодотгоогүй байна. 2022 онд Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 382,591.4 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 382,591.4 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, гүйцэтгэлээр 340,645.2 мянган төгрөг буюу 89.0 хувийг зарцуулан, 41,946.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Энэ нь 2 орон тоо дутуу ажилласнаас цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамжийн материалын зардлыг тус тус хэмнэж Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Хөтөлбөр арга хэмжээ				
Нийт дүн			382,591.4	340,645.2	41,946.2	89.0
1	70805	80101	353,751.4	311,911.7	41,839.7	88.2
2		80802	23,240.0	23,133.5	106.5	99.5
3	70802	80101	4,000.0	4,000.0	-	100.0
4	72101	80101	1,600.0	1,600.0	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилж ХХААХҮЯ-наас 7,300.0 мянга, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 21,748.9 мянган нийт 29,048.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 29,048.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын зардлын эдийн засгийн ангилалтай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Цэрэнлхам гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 30 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвөөс 382,591.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,738.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,304.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах заримыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д Төрийн өмчид бүртгэлтэй 22-28БУА, 99-82БУА улсын дугаартай авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 152 мэдээлэл мэдээлэхээс бүрэн мэдээлж ажилласан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант онд төсвийн шууд захирагчид завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 21/210 дугаар албан тоотоор ирүүлсэн.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	7,200.00	2	7,200.00	100
Нийт дүн	2	7,200.00	2	7,200.00	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын гүйцэтгэх цаг хугацааны нөөц, цар хүрээ хязгаарлагдмал байсан учраас дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэлд бүрэн тооллогын горим сорил хэрэгжүүлэн, өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, 2022 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын тайланд дурдсан зүйлсийг шийдвэрлэсэн байдал, цаг бүртгэлийн мэдээ тайлан, илүү цагийн тооцоог зэргийг тусгайлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 42,859.8 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Цалингийн зардлыг тооцоолсон цалингаар тооцооны дансаар дамжуулаагүй, НДШ, ХХОАТ, бусад өглөгийг шууд зардлаар бүртгэснийг залруулсан.

Аудитаар нийт 3,405.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 3,405.8 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нэмэлтийн зарцуулалтын эрхийг зардлын эдийн засгийн ангиллаар нээлгээгүй бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, бараа ажил үйлчилгээний бусад зардлаар нээж өгснөөс бичиг хэргийн материал, аж ахуйн материал, шатахуун зэрэг худалдан авалт хийж эдийн засгийн ангиллыг буруу бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Эдийн засгийн ангилал ашиглах заавар"-д 210801 -Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж "Гуравдагч этгээдийн багц үйлчилгээг худалдан авахад төлөх энэ бүлэг (2108)-т зааснаас бусад ажил, үйлчилгээний төлбөр хураамжууд энд хамаарна" гэж заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн эдийн засгийн ангилал хооронд шилжүүлж худалдан авалт хийхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн зардлыг тооцоолсон цалингаар тооцооны дансаар дамжуулаагүй, НДШ, ХХОАТ, бусад өглөгийг	1	42,859.8	-	-	1	42,859.8	1	42,859.8	0	-	0	-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

шууд зардлаар бүртгэсэн6												
Дүн	1	42,859.8	-	-	1	42,859.8	1	42,859.8	0	-	0	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
											Тоо	Дүн
Нэмэлтийн зарцуулалтын эрхийг зардлын эдийн засгийн ангиллаар нээлгээгүй бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, бараа ажил үйлчилгээний бусад зардлаар нээж өгснөөс бичиг хэргийн материал, аж ахуйн материал, шатахуун зэрэг худалдан авалтыг эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн хийсэн байна.	1	3,405.8	-	-	-	-	1	3,405.8	-	-	-	-
Дүн	1	3,405.8	-	-	-	-	1	3,405.8	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн тухай хууль								
Төрийн өмчид бүртгэлтэй 22-28 БУА, 99-82 БУА улсын дугаартай авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-